



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар Б/Н

Хэрлэн сум

Т.Отгонтуяаг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.20, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 43 дугаар зүйлийн 43.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт, 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2024 оны “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 82 дугаар тогтоолын хавсралт, Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтад орж тэнцсэн тул Төмөртоогогийн Отгонтуяаг Нийтийн номын сангийн захиралын албан тушаалд 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын
дарга:

Н.Зоригтбаатар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Д.Должинсүрэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

С.Болортуяа

Нийтийн номын сангийн Нягтлан бодогч

3. Т.Отгонтуяагийн үндсэн цалинг ТҮСБ-6 зэрэглэлээр тогтоон, үндсэн цалин 1,621,000 (нэг сая зургаан зуун хорин нэгэн мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан

2.

хугацааны нэмэгдлийг 17 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 20 хувиар тус тус тооцож олгохыг нийтийн номын сангийн нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

4.Нийтийн номын сангийн захиралын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Т.Отгонтуяад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ